



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/7520

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн бүртгэлээс
барилга байгууламж хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4.2 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сүхбаатар дүүргийн 16 дугаар цэцэрлэгийн балансад бүртгэлтэй нийт 14,233,300.00 (арван дөрвөн сая хоёр зуун гучин гурван мянга гурван зуу) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 8,572,052.50 (найман сая таван зуун далан хоёр мянга тавин хоёр төгрөг тавин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад дурдсан барилга байгууламжийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн 16 дугаар цэцэрлэг (Д.Оюунчимэг)-т зөвшөөрсүгэй.

2.Барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой эд хөрөнгийг худалдан борлуулж 738,000.00 (долоон зуун гучин найман мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэхийг Сүхбаатар дүүргийн 16 дугаар цэцэрлэг (Д.Оюунчимэг)-т, орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110206925

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
12 дүгээр сарын 29-ны өдрийн
14.15.20.9 дүрээр захирамжийн
хавсралт

АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ НИЙСЛЭЛИЙН 16 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Хүчин чадал	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2024.10.01/	Үлдэгдэл өртөг
1	Агуулахын барилга	м2	66	2011	5,783,400.00	554,252.50	5,229,147.50
2	Үзелийн барилга	м2	30,12	1970	8,017,800.00	8,017,800.00	-
3	Бут	ш	72	1996	432,100.00	-	432,100.00
	Нийт дүн				14,233,300.00	8,572,052.50	5,661,247.50